



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ  
2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ  
2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 11.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 195-196, 198-202 дахь зүйлийг тус тус үндэслэн:

**Нэг талаас** Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захиргач С.Энхболд /цаашид “Захиалагч” гэх/.

**Нэгөө талаас** Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал /цаашид “Хэрэгжүүлэгч” гэх/ нар энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Гэрээний зорилго нь аймгийн Засаг даргад хууль тогтоомжоор олгосон нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ, Засгийн газар, УОК-оос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьялах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тэгш хүртээмжтэй, чанартай, шуурхай байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээтэй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга), Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

1.3. Гэрээний талууд харьялах нутаг дэвсгэрийн хүн амд коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг сайжруулах, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хүн амд үзүүлэх тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг санхүүжүүлэх зарчмыг баримтална.

1.4. Гэрээг хоёр эх хувь үйлдэв.

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

2.1. Захиалагч нь эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусlamж, үйлчилгээний санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.1 Аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

2.1.2 Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тохиолдолд суурилсан тусlamж, үйлчилгээний санхүүжилтийг гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

2.1.3 Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлэх бөгөөд нэг иргэнд ногдох төсвийг гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүжүүлнэ.

2.2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

2.3. Гэрээний хэрэгжилтийн явцад үссэн нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд зохицуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч, харилцан уялдаатай ажиллана.

2.4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цартахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн салбараас авах хариу арга хэмжээ, нөөцийн бэлэн байдлыг төлөвлөх, бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад нэгдсэн дэмжлэгт удирдлагаар хангана.

2.5. Коронавируст халдварт (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвартын үеийн оношилгоо, эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэвийн тасралтгүй үзүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд ажиллана.

2.6. Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудаас авах хариу арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг тухай бүрт солилцон тулгамдаж буй асуудлыг харилцан шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллана.

2.7. Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудаас авах хариу арга хэмжээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.8. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар холбогдох тушаал, шийдвэр, арга зүйн зөвлөмж, мэдээллийг тухай бүрт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавина.

2.9. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, нас барагтыг бууруулах болон бусад эрүүл мэндийн чиглэлээр зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд хамтран ажиллана.

2.10. Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд хамтран ажиллана.

2.11. Хэрэгжүүлэгчийг эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж буй бодлогын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар бүрэн хангаж, аймгийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа, санаачлагыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

#### **Гурав. Хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг**

3.1. Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022

оны төлөвлөгөө, эрүүл мэндийн чиглэлээрх арга хэмжээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.

3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Бүх нийтийг хамруулах”, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тусламж, үйлчилгээг “Үйлчлүүлэгч төвтэй” байхаар зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бусад салбар, олон нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог ханганд ажиллана.

3.3. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2022 оны I улиралд багтаан Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах ажлыг холбогдох хууль, журам, удирдамжийн дагуу зохион байгуулахад нэгдсэн эмнэлэгт дэмжлэг үзүүлж, Эрүүл мэндийн яамнаас өгсөн чиглэл, арга зүйн хүрээнд хамтран ажиллана.

**3.2.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цартахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр:**

3.2.1.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цартахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр салбар дундын мэргэжлийн байгууллагыг оролцуулан эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангах нөөц бүрдүүлэх, хяналт тавьж ажиллана.

3.2.1.2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалт, ялангуяа хилийн нэвтрэх цэгтэй аймагт лабораториид суурилсан тандалт хийх, өвчлөл зөөвөрлөгдөхөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1.3. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цартахлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, “хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим” баримтлан ажиллана.

3.2.1.4. Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж, полимеразын гинжин урвал (ПГУ) шинжилгээ хийх болон антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх чадавхийг бүрдүүлж, урвалж, бодисоор тасралтгүй хангана.

3.2.1.5. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үйл ажиллагаанд зориулан ашиглаж буй програм хангамж, цахим системийн мэдээллийн санг чанартай бүрдүүлэн, өдөр тутамт хяналт тавьж ажиллах ба иргэдэд дараах мэдээллийг цахимаар гарган өгнө. Үүнд:

- КОВИД-19 халдвартын шинжилгээний хариу;
- КОВИД-19 халдвартын дархлаажуулалтын сертификат;
- Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ;
- КОВИД-19 халдвартын Эмнэлгийн магадлагаа;
- КОВИД-19 халдвартын QR батламж.

3.2.1.6. Коронавируст халдварт (КОВИД-19) харьяа нутаг дэвсгэрт бүртгэгдсэн тохиолдолд анхан шатлалын тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэлийн чанарт хяналт тавьж ажиллана.

3.2.1.7. Нийт хүн ам болон зорилтот бүлэгт зориулсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулна.

3.2.1.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлын үед чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсээр хүн амыг тасралтгүй хангах ялангуяа, орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.1.9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлын үед халдвартгүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлэх, тасралтгүй хуваарилах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ урьдчилан сэргийлэх, голомтын халдвартгүйжүүлэлтийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна.

3.2.1.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдвартын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалтад цахимаар хамрагдах боломж, нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

3.2.1.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх голомтын болон шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх үед эрүүл мэндийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

3.2.1.12. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал болон коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажилласан эрүүл мэндийн ажилтны цалин, урамшууллын асуудлыг Эрүүл мэндийн тухай хууль, Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж ажиллана.

3.2.1.13. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эрүүл мэндийн байгууллагуудын жигд, тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор тусламж, үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног, төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, шатахуун, тослох материал, сэлбэгийг Аймгийн Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2.1.14. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн хангалт, сургалт зэрэгт дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана.

3.2.1.15. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр тухай бүрт гарч байгаа хууль, дүрэм, тушаал, зааврыг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

### **3.2.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:**

3.2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.2.2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих цогц, арга хэмжээ ("Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", халдварт бус өвчин, халдварт өвчин, орчны эрүүл мэнд болон бусад)-г орон нутгийн түвшинд хэрэгжүүлж ажиллана.

3.2.2.3. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчин (элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт зэрэг)-ний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд иргэн бүрийг хамруулах, иргэдэд өгөх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн салбар хоорондын уялдааг ханганд ажиллана.

3.2.2.4. Сургуулийн өмнөх болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, хуртээмж, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, осол, гэмтлээс сэргийлэх, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангана.

3.2.2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчиний дэгдэлт, цартахлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана.

3.2.2.6. Сүрьеэз өвчиний илрүүлэлтийн хувийг зорилтот түвшинд (хавсралт) хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцно.

3.2.2.7. Бэлгийн замаар дамжих халдварт (БЗДХ)-ыг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон ажиллана.

3.2.2.8. Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нэлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт) зэрэг салбар дундын хамтын ажиллагааг ханганд ажиллана.

3.2.2.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулна.

3.2.2.10. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүх барьж, ашиглах, нийгмийн эзэмшлийн зам, талбайд нус, цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлж ажиллана.

3.2.2.11. Орчны эрүүл мэндийг сайжруулахад салбар дундын оролцоог хангах, ундны ус, хөрс агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нэлөөллийг тандан судлах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, ундны ус, хэрэглээний бохир усанд мэргэжлийн байгууллагаар тогтмол давтамжтайгаар шинжилгээ хийлгэн, шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг ханганд, засвар үйлчилгээний үед ажилтан, албан хаагчийн аюулгүй байдлыг хангана.

3.2.2.12. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, идэвх, санаачлагатай, шинэлэг хэлбэрээр салбар дундын хамтын ажиллагааг ханганд ажиллана.

3.2.2.13. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

### 3.2.4. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

3.2.4.1.Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.

3.2.4.2. Орон нутгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг үнэн зөв бүртгэх, түр оршин суугч, явуулын иргэдэд үзүүлэх тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

3.2.4.3. Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ”-г бүх сумдад зохион байгуулна.

3.2.4.4. Тусlamж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэхэд анхаарна.

3.2.4.5. Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3.2.4.6. Анхан шатлалын эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

### **3.2.5. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр:**

3.2.5.1. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусlamж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулна.

3.2.5.2. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавина.

3.2.5.3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулна (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаал).

3.2.5.4. Хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавина.

3.2.5.5. Байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд saatуулах, өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэрээр эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2.5.6. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.

3.2.5.7. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар жилдээ нэгээс доошгүй удаа хэлэлцүүлж, тодорхой шийдвэр гаргана.

3.2.5.8. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

**3.2.6. Аймгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний чиглэлээр:**

3.2.6.1. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд тусlamж, үйлчилгээний эмнэл зүйн олон улсын удирдамж "Up to Date" платформыг үргэлжлүүлэн нэвтрүүлж бүх эмч нар ашиглах боломжийг хангана.

3.2.6.2. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчтэй байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.2.6.3. Эмнэлгийн яаралтай тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тусlamж, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

3.2.6.4. Уламжлалт анагаах ухааны төв, нэгдсэн эмнэлгийн тусlamж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогод үйл ажиллагаа болон хүний нөөцийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ, төсөв хөрөнгийг тусгаж, хэрэгжилтэд анхаарна.

3.2.6.5. Эрүүл мэндийн байгууллага бүрт Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавьж ажиллана.

3.2.6.6. Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.2.6.7. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

3.2.6.8. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн байдалд тогтмол хяналт тавьж нөөцийн талаарх мэдээллийг сар бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр Засаг даргын хурлаар хэлэлцэж шаардлагатай хариу арга хэмжээ шуурхай авна.

3.2.6.9. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.2.6.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусlamж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.2.6.11. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, оношилгоо, эмчилгээний дутууг нөхөн тусlamж, үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцон ажиллана.

3.2.6.12. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

### **3.2.7. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр:**

3.2.7.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тасралтгүй байдлыг хангана.

3.2.7.2. Эрүүл мэндийн яамны Цахим эрүүл мэндийн удирдах хороо, техникийн ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрээр албан ёсны програм хангамж, цахим системийг эрүүл мэндийн байгууллагад ашиглаулна.

3.2.7.3. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын холбогдох стандарт, журмыг мөрдүүлнэ.

3.2.7.4. Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний мэдээ, мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, дамжуулахтай холбоотой цахим соёлыг төлөвшүүлнэ.

3.2.7.5. Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний үр дүнг иргэдэд бодит цаг хугацаанд, шуурхай, хялбар олгоход чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2.7.6. Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана.

3.2.7.7. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (төлемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.

3.2.7.8. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн "E-Health" программ хангамжийн ашиглалтыг сайжруулж үйл ажиллагааг жигдүүлнэ.

3.2.7.9. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудыг өндөр хурдны интернетийн шилэн кабель, эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээнд холбоно.

### **3.2.8. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр:**

3.2.8.1. Орон нутгийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвортой суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.2.8.2. Орон нутагт эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлж, эмч, сувилагчийн харьцааг 1:2-т хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн захиалгаар жилд сувилагч мэргэжлээр 3-4 суралцагчийг шинээр сургах зардлыг шийдвэрлэнэ.

3.2.8.3. Үр бүтээлтэй ажиллаж байгаа орон нутгийн эрүүл мэндийн удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэнд олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллана.

3.2.8.4. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, орон нутгийн эмнэлгийн мэргэжилтэнг лавлагaa шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад дадлагажуулан сургах, лавлагaa шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын эмнэлгийн

мэргэжилтэнг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, орон нутгийн анхан шатлалын тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллана.

3.2.8.5. Төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2.8.6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.2.8.7. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 378 дугаар тогтоолоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжиж ирэх эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нарыг аймгийн Эрүүл мэндийн газарт байрлуулан ажиллуулах нөхцөл боломжоор хангаж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана.

**Бусад үйл ажиллагааны чиглэлээр:**

3.2.9. Тусгай зөвшөөрлийн хэрэгцээний үнэлгээ хийх, тусгай зөвшөөрлийн ажлын байрны үзлэг, нөхцөл шаардлагад тавих хяналтын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэгийн оролцоог хангаж, холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахад нэгдсэн удирдамжаар хангана.

3.2.10. Тухайн орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт (тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ), бусад дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2.11. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний догондоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.

3.2.12. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусlamж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

3.2.13. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана.

**Дөрөв. Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт**

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулахад энэхүү гэрээ болон Эрүүл мэндийн газрын саналыг харгалзана.

4.1. Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2. Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

4.4. Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.5. Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна.

4.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь харьяа нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, бусад харьяа эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж, тайлангаа Эрүүл мэндийн яамны дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

4.8. Хэрэгжүүлэгч нь гэрээний биелэлтийг тухайн жилийн хагас жилийн байдлаар 07 дугаар сарын 15, жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор тайлагнана.

#### **Тав. Улсын төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг санхүүжүүлэх**

5.1. Эрүүл мэндийн газрын санхүүжилтийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөв болон Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан олгоно.

5.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан Тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулах санхүүжүүлнэ.

5.3. Сангийн яамны Төрийн сангийн газар нь санхүүжилтийн төлбөрийг Хэрэгжүүлэгчийн захирал зарцуулах эрх бүхий Төрийн сангийн дансанд сар бүрийн тогтсон хуваарыт өдрүүдэд багтаан шилжүүлэх үүрэг хүлээнэ.

5.4. Захиалагч нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн нэгдсэн дансанд

орсоноос хойш ажлын 2 хоногийн дотор орон нутгийн тусгай зориулалтын байгууллагуудын дансанд шилжүүлнэ.

### **Зургаа. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, үнэлэх**

6.1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиг үүргийг Засгийн газрын өмнө төлөөлөн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал зардал болон бусад зардал, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр баталж үнэлнэ. Үүнд:

- 6.1.1. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт;
- 6.1.2. Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны төсөв;
- 6.1.3. 2022 оны хөрөнгө оруулалт.

6.2. Гэрээний хэрэгжилтийг Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгон, хагас жилд үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр, бүтэн жилд гэрээний заалт бүрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

6.3. Захиалагч нь гэрээний үүргийн биелэлтэд үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 04 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлнэ.

### **Долоо. Гэрээний хугацаа**

Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа 2022 оны төсвийн жилийн хүрээнд үйлчилнэ.

### **Найм. Гэрээний үнэ**

8.1. Энэхүү гэрээний нийт төсөвт өртөг 3,417,198.9 мянган төгрөг болон гүйцэтгэлээр санхүүжих төсөв байна.

8.2. Хэрэгжүүлэгчийн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсөв, хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжилтийг нэмэгдүүлж болно.

### **Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах**

9.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр мэдэгдэж, харилцан зөвшилцэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн Захиалагч, Хэрэгжүүлэгч гарын үсэг зурж, гэрээний эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг Захиалагч болон Хэрэгжүүлэгч хадгална.

9.3. Гэрээнд тусгагдаагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцэж, нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно. Ингэхдээ Захиалагчийн төсөвт өртгөөс давсан тохиолдолд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан зарчмыг удирдлага болгон төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

9.4. Захиалагч гэрээний биелэлтийн үнэлгээний дүнг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

### **Арав. Талуудын хүлээх хариуцлага.**

10.1. Гэрээний талууд энэхүү гэрээгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын өмнө хамтран хүлээнэ.

10.2. Гэрээний шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд Захиалагчаас гүйцэтгэгчийг мөнгөн бус хэлбэрээр урамшуулна.

### **Арваннэг. Маргааныг шийдвэрлэх**

11.1. Төлбөрийн шилжүүлэгтэй холбогдон үүссэн маргааныг Сангийн яаманд хандаж, зохицуулах арга хэмжээг авна.

11.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг гэрээний талууд зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.3. Зөвшилцэлд эс хүрвэл шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

### **Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох**

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

### **Арвангурав. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг**

13.1. Энэхүү гэрээ нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

13.1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ;

13.1.2. Хавсралт 1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын үзүүлэлт;

13.1.3. Хавсралт 2. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны төсөв;

13.1.4. Хавсралт 3. 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт;

13.1.5. Хавсралт 4. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг тайлгахаа загвар.

ЗАХИАЛАГЧ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ


  
С. ЭНХБОЛД

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

  
БАЗЖАРГАЛ

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр  
Улаанбаатар хот



## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2021 он/	Хүрэх түвшин /2022 он/
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	53.9	58.9
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	100.0	100.0
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	18272	19186
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	52.3	57.3
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	32.6	37.6
6	В вируст хепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	100.0	Суурь үзүүлэлтээс доошгүй
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В хепатит, хемофилус инфлюэнза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	100.0	Суурь үзүүлэлтээс доошгүй
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГҮ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	100.0	Суурь үзүүлэлтээс доошгүй
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	136.7	0.0
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	9.6	9.1
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	7.3	6.8
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	10.9	10.2
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	3.2	2.7
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	92.6	95.6
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	10.4	9.4
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	8.6	8.1
17	Вируст хепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	0.5	0.2
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	19.7	19.5
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	13.3	12.8
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.4	0.2

21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /Х40-Х49/	0.9	0.6
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, (10 000 хүүхдэд, Т20-T32)	46.4	45.4
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.6	0.4
24	Шинээр ажилд авсан сувилагчийн тоо		Гүйцэтгэлээр
25	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
26	Хүний нөөцийг бурдүүлэх 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
27	Орон нутгаас байр, орон сууцаар хангасан эмч, мэргэжилтний тоо		Гүйцэтгэлээр
28	Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт (чиглэл, төгрөгөөр, хувиар)		Гүйцэтгэлээр
29	Сувилагч мэргэжлээр тайлангийн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ суралцагчийн тоо		Гүйцэтгэлээр
30	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих, тогтвортой суурьшилтай ажиллуулах чиглэлээр Засаг дарга, ИТХ-ын түвшинд гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
31	Тайлангийн жилд орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхийг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мянган төгрөгөөр/		Гүйцэтгэлээр

**Тайлбар:**

- Нас баралт, өвчлөлийн түвшинг 2020 оны дундаж хүн амын тоогоор тооцоолсон.
- Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хамралтын хувийг урьдчилсан байдлаар тооцоолсон.
- Дархлаажуулалтын хамралтын хувийг урьдчилсан байдлаар тооцоолсон.

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ТӨСӨВ

/мян.төг/

	ХӨДӨЛГӨРӨГЧИЙН ЗАРДАЛ
Дархан-Уул	3,417,198.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	3,417,198.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,417,198.9
БАРАА, ЙИЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,417,056.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	995,830.3
Їндсэн цалин	603,906.9
Нэмэгдэл	216,354.3
Унаа хоолны Хөнгөлөлт	80,850.0
Урамшуулал	94,719.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,911.9
Тэтгэврийн даатгал	100,237.0
Тэтгэмжийн даатгал	9,168.7
ЇОМШ-ний даатгал	7,335.0
Ажилгүйдлийн даатгал	1,833.7
Эртэл мэндийн даатгал	18,337.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,887.1
Гэрэл, цахилгаан	18,504.7
Тілш, халаалт	25,847.7
Цэвэр, бохир ус	7,916.7
Байрны төрээс	4,618.0
Хангамж, бараа материалын зардал	36,760.3
Бичиг хэрэг	6,617.2
Тээвэр, шатахуун	13,432.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,455.2
Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,500.0
Бага юнэтэй, төргэн элэгдэх, ахуйн эд зийлс	5,755.9
Нормативт зардал	45,702.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,882.5
Нормын хувцас, зөвлөн эдлэл	4,820.0
Эд хогшил, урсгал засварын зардал	24,750.1
Багаж, техник, хэрэгсэл	12,500.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708.6
Урсгал засвар	9,541.5
Томилолт, зочны зардал	7,936.0
Дотоод албан томилолт	7,936.0
Бусдаар гүйцэтгүйлсэн ажил, йилчилгээний төлбөр, хураамж	71,986.3
Бусдаар гүйцэтгүйлсэн бусад нийтлэг ажил, йилчилгээний төлбөр	47,692.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,412.0
Даатгалын йилчилгээ	2,228.6
Тээврийн хэрэгслийн татвар	369.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	198.0
Мэдээллийн технологийн йилчилгээ	16,370.8
Газрын төлбөр	816.4
Банк, санхүүгийн байгууллагын йилчилгээний хураамж	99.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800.0
Бараа йилчилгээний бусад зардал	40,291.7
Бараа йилчилгээний бусад зардал	38,208.8
Хичээл йилдвэрлэлийн дадлага хийх	2,082.9

УРСГАЛ ШИЛЖІЛЭГ	2,000,142.7
Бусад урсгал шилжілэг	2,000,142.7
Тэтгэвэрт гаражад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,262.6
Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагч	1,171,480.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400.0
ЗАРДЛЫГ САНХІЛЭЛЭХ ЭХ ЦСВЭР	3,417,198.9
Улсын төсвөөс санхүйжих	3,417,198.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	176.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	70.0
Удирдах ажилтан	1.0
Гийцэтгэх ажилтан	45.0
Үйлчлэх ажилтан	24.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.0
Төрийн захиргааны албан хаагч (Т3)	5.0
Эрэл мэндийн салбарын төрийн Үйлчилгээний албан хаагч (Т1Э)	47.0
Төрийн Үйлчилгээний бусад албан хаагч (Т1)	18.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	35.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	35.0
Эрэл мэндийн газар	3,417,198.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	3,417,198.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,417,198.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,417,056.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	995,830.3
Їндсэн цалин	603,906.9
Нэмэгдэл	216,354.3
Унаа хоолны Хөнгөлөлт	80,850.0
Урамшуулал	94,719.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,911.9
Тэтгэврийн даатгал	100,237.0
Тэтгэмжийн даатгал	9,168.7
ЇОМШ-ний даатгал	7,335.0
Ажилгүйдлийн даатгал	1,833.7
Эрэл мэндийн даатгал	18,337.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,887.1
Гэрэл, цахилгаан	18,504.7
Түлш, халаалт	25,847.7
Цэвэр, бохир ус	7,916.7
Байрны төрэс	4,618.0
Хангамж, бараа материалын зардал	36,760.3
Бичиг хэрэг	6,617.2
Тээвэр, шатахуун	13,432.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,455.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,500.0
Бага юэтэй, төргэн элэгдэх, ахуйн эд зийлс	5,755.9
Нормативт зардал	45,702.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,882.5
Нормын хувцас, зөвлөн эдлэл	4,820.0
Эд хогшил, урсгал засварын зардал	24,750.1
Багаж, техник, хэрэгсэл	12,500.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708.6
Урсгал засвар	9,541.5
Томилолт, зочны зардал	7,936.0

Дотоод албан томилолт	7,936.0
Бусдаар гийцэтгэлсэн ажил, тайлчилгээний төлбөр, хураамж	71,986.3
Бусдаар гийцэтгэлсэн бусад нийтлэг ажил, тайлчилгээний төл	47,692.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,412.0
Даатгалын тайлчилгээ	2,228.6
Тээврийн хэрэгслийн татвар	369.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	198.0
Мэдээллийн технологийн тайлчилгээ	16,370.8
Газрын төлбөр	816.4
Банк, санхүүгийн байгууллагын тайлчилгээний хураамж	99.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800.0
Бараа тайлчилгээний бусад зардал	40,291.7
Бараа тайлчилгээний бусад зардал	38,208.8
Хичээл тайлдвэрлэлийн дадлага хийх	2,082.9
УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	2,000,142.7
Бусад урсгал шилжилэг	2,000,142.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,262.6
Хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан албан х	1,171,480.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖИЛЛЭХ ЭХ ЙСВЭР	3,417,198.9
Улсын төсвөөс санхүүжих	3,417,198.9
Улсын төсвөөс санхүүжих	3,417,198.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	176.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	70.0
Удирдах ажилтан	1.0
Гийцэтгэх ажилтан	45.0
Тайлчлэх ажилтан	24.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.0
Төрийн захирагааны албан хаагч (Т3)	5.0
Эрүүл мэндийн салбарын төрийн тайлчилгээний албан хаагч (	47.0
Төрийн тайлчилгээний бусад албан хаагч (Т1)	18.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	35.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	35.0
Їндсэн тайл ажиллагааны зардал	1,367,606.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	1,367,606.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,367,606.2
БАРАА, ТАЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,367,606.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	995,830.3
Їндсэн цалин	603,906.9
Нэмэгдэл	216,354.3
Унаа хоолны Хөнгөлөлт	80,850.0
Урамшуулал	94,719.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,911.9
Тэтгэврийн даатгал	100,237.0
Тэтгэмжийн даатгал	9,168.7
ЇОМШ-ний даатгал	7,335.0
Ажилгүйдлийн даатгал	1,833.7
Эрүүл мэндийн даатгал	18,337.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,887.1
Гэрэл, цахилгаан	18,504.7
Тілш, халаалт	25,847.7
Цэвэр, бохир ус	7,916.7
Байрны төрээс	4,618.0

Хангамж, бараа материалын зардал	36,760.3
Бичиг хэрэг	6,617.2
Тээвэр, шатахуун	13,432.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,455.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	8,500.0
Бага юнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зийлс	5,755.9
Нормативт зардал	45,702.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,882.5
Нормын хувцас, зөслөн эдлэл	4,820.0
Эд хогшил, ургал засварын зардал	24,750.1
Багаж, техник, хэрэгсэл	12,500.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708.6
Ургал засвар	9,541.5
Томилолт, зочны зардал	7,936.0
Дотоод албан томилолт	7,936.0
Бусдаар гийцэтгэлсэн ажил, тайлчилгээний төлбөр, хураамж	45,586.3
Бусдаар гийцэтгэлсэн бусад нийтлэг ажил, тайлчилгээний	21,292.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,412.0
Даатгалын тайлчилгээ	2,228.6
Тээврийн хэрэгслийн татвар	369.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	198.0
Мэдээллийн технологийн тайлчилгээ	16,370.8
Газрын төлбөр	816.4
Банк, санхүүгийн байгууллагын тайлчилгээний хураамж	99.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800.0
Бараа тайлчилгээний бусад зардал	17,241.7
Бараа тайлчилгээний бусад зардал	15,158.8
Хичээл тайлдвэрлэлийн дадлага хийх	2,082.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖИЛЛЭХ ЭХ ПСВЭР	1,367,606.2
Улсын төсвөөс санхүүжих	1,367,606.2
Улсын төсвөөс санхүүжих	1,367,606.2
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	141.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	70.0
Удирдах ажилтан	1.0
Гийцэтгэх ажилтан	45.0
Тайлчлэх ажилтан	24.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.0
Төрийн захиргааны албан хаагч (Т3)	5.0
Эртөл мэндийн салбарын төрийн тайлчилгээний албан хаа	47.0
Төрийн тайлчилгээний бусад албан хаагч (Т1)	18.0
Харул, хамгаалалтын зардал	26,400.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	26,400.0
УРСГАЛ ЗАРДАЛ	26,400.0
БАРАА, ТАЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,400.0
Бусдаар гийцэтгэлсэн ажил, тайлчилгээний төлбөр, хураамж	26,400.0
Бусдаар гийцэтгэлсэн бусад нийтлэг ажил, тайлчилгээний	26,400.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖИЛЛЭХ ЭХ ПСВЭР	26,400.0
Улсын төсвөөс санхүүжих	26,400.0
Улсын төсвөөс санхүүжих	26,400.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,000,142.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	2,000,142.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,142.7
УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	2,000,142.7

Бусад урсгал шилжүүлэг	2,000,142.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,262.6
Хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан алба	1,171,480.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮРЛЭХ ЭХ ПСВЭР</b>	<b>2,000,142.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,000,142.7
Улсын төсвөөс санхүүжих	2,000,142.7
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>35.0</b>
<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>35.0</b>
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	35.0
Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	23,050.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДИН</b>	<b>23,050.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,050.0</b>
<b>БАРАА, ЙИЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>23,050.0</b>
Бараа йилчилгээний бусад зардал	23,050.0
Бараа йилчилгээний бусад зардал	23,050.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮРЛЭХ ЭХ ПСВЭР</b>	<b>23,050.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	23,050.0
Улсын төсвөөс санхүүжих	23,050.0

Хавсралт 3

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦАД  
2022 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Санхүүжих дүн (сая төгрөг)
XIX.1.34	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Хонгор сум/	2021	2022	485.2	285.2
XIX.3.1	Геронтологийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2022	500.0	150.0
XIX.3.2	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 6, 7, 8, 9, Өргөө баг/	2020	2022	398.6	48.6
XIX.3.5	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2022	800.0	14.8